



2002 оны 5 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

## БОЛОВСРОЛЫН ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### Нийтлэг үндэслэл

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь боловсролын үндсэн зарчим, тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, иргэний сурч боловсрох эрхийг хангахтай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Боловсролын тухай хууль тогтоомж

2.1.Боловсролын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

[/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."бүх нийтийн ерөнхий боловсрол" гэж 12 жилийн сургалтын агуулгын түвшинг;

[/Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

3.1.2."суурь боловсрол" гэж 9 жилийн сургалтын агуулгын түвшинг;

3.1.3."боловсролын агуулга" гэж боловсролын тухайн түвшинд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал, төлөвшлийн цогцыг;

3.1.4."боловсролын түвшин" гэж тухайн шатанд эзэмшвэл зохих сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын агуулгын стандартаар тогтоосон мэдлэгийн хэмжээг;

3.1.5."сургалтын байгууллага" гэж боловсролын нэг буюу хэд түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлдэг хуулийн этгээдийг;

3.1.6."албан боловсрол" гэж боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагааг;

3.1.7."албан бус боловсрол" гэж боловсролын албан ёсны тогтолцоонос гадуур иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалттай үйл ажиллагааг;

3.1.8."багц цаг" гэж дээд болон мэргэжлийн боловсролын агуулгын багтаамжийг хэмжих нэгжийг.

3.1.9."хөгжлийн бэрхшээлтэй суралцагч" гэж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан иргэнийг;

[/Энэ заалтыг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ заалтад 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

3.1.10."сургалтын орчин" гэж боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд шаарддагдах материаллаг нөхцөл болон сурх, сургах харилцааг;

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

3.1.11."төлөвшил" гэж суралцагчийн хүмүүжил, итгэл үнэмшлийн цогцыг;

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

3.1.12."сургуулийн нийгмийн ажилтан" гэж суралцагч, эцэг эх болон багшийн харилцаа, тэдний нийгмийн асуудлаар үнэлгээ

хийх, ганцаарчилсан болон бүлэгт чиглэсэн мэргэжлийн зөвлөгөө өгөх замаар нийгмийн сөрөг үзэгдлээс хүүхдийг урьдчилан сэргийлэх, тэдний төлөвшил, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг мэргэжилтэнг.

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн. Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

3.1.13."олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль" гэж олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий боловсролын хөтөлбөрөөр хичээллэдэг сургуулийг;

[/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

3.1.14."ерөнхий боловсролын лаборатори сургууль" гэж бага, дунд боловсролын судалгаа, арга зүйн туршилтыг зохион байгуулах ерөнхий боловсролын сургуулийг;

[/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

3.1.15."боловсролын туслах ажилтан" гэж бүх шатны боловсролын сургалтын байгууллагын нягтлан бодогч, нярав, тогооч, манаач, үйлчлэгч, мужаан, цахилгаанчин, слесарь, галч болон үйлчилгээний бусад ажилтныг.

[/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

3.1.16."ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллага" гэж сургалтын үйл ажиллагаа явуулах үндсэн зорилготой, үйл ажиллагаанаасаа олсон ашгийг /орлогыг/ зөвхөн үндсэн зорилгын дагуу зарцуулдаг, үндсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагддаггүй хуулийн этгээдийг;

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

3.1.17."ашгийн төлөө боловсролын сургалтын байгууллага" гэж хувь оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилдаг бөгөөд ашиг олох зорилгоор сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг;

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

3.1.18."сургалтын цөм хөтөлбөр" гэж тухайн шатанд суралцагчийн эзэмших мэдлэг, ур чадвар, төлөвшлийн түвшин, түүнд хүрэх цогц үйл ажиллагааны ерөнхий зохион байгуулалтыг илэрхийлсэн баримт бичгийг;

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

3.1.19."өдөр өнжүүлэх үйлчилгээ" гэж эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу сургалтын байгууллага иргэнтэй харилцан тохиролцож үйлдсэн гэрээний үндсэн дээр эрүүл, аюулгүй орчинд хүүхдийг асрах, хамгаалах, хөгжлийг дэмжих сургалтаас гадуур үзүүлэх үйлчилгээг;

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

3.1.20."насан туршийн боловсрол" гэж бүх насны иргэд боловсролын албан болон албан бус хэлбэрээр ёс суртахуун, гоо зүй, иргэн, гэр бүл, шинжлэх ухаан, амьдрах ухааны боловсролыг тасралтгүй эзэмших үйл ажиллагааг

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

#### 4 дүгээр зүйл.Боловсролын зорилго

4.1.Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.

#### 5 дугаар зүйл.Боловсролын үндсэн зарчим

5.1.Боловсролын үндсэн зарчим нь:

5.1.1.боловсролыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төрийн ивээл, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад байлгана;

5.1.2.Монгол Улсад боловсрол нь хүмүүнлэг, ардчилсан, тасралтгүй, бүх нийтэд хүртээмжтэй байх бөгөөд үндэсний болон хүн төрөлхтөний соёл иргэншлийн үнэт зүйлс, дэвшилт өв уламжлал, шинжлэх ухаанд тулгуурлана;

5.1.3.боловсрол эзэмшүүлэх арга, хэлбэр, суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байна;

[/Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

5.1.4.иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана;

[/Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

5.1.5.нийг, иргэний эрх ашиг, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө бүхий, гадаад улсын санхүүжилт, зохион байгуулалттайгаар шашны чиглэлээр сургалт, шашны зан үйл, бусад үйл ажиллагаа сургалт зохион байгуулахыг хориглоно;

[/Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

5.1.6.өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр боловсролын байгууллагад адил тэгш хандана.

## **6 дугаар зүйл.Иргэний сурч боловсрох үндсэн эрх, үүрэг**

6.1.Монгол Улсын иргэн бүх шатны боловсролыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу төлбөргүй буюу төлбөртэйгээр сурч эзэмших, ажил эрхлэхийн зэрэгцээ суралцах эрхтэй.

6.2.Үндсэн хуульд заасны дагуу төрөөс бүх нийтийн өрөнхий боловсролыг төлбөргүй олгоно.

6.3.Монгол Улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй.

6.4.Иргэн тодорхой хугацаанд мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдах, бие даан суралцах замаар боловсрол, мэргэшлийн ур чадвараа байнга дээшлүүлж байх үүрэгтэй.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

## **7 дугаар зүйл.Боловсролын тогтолцоо**

7.1.Монгол Улсад боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролоос бүрдэнэ.

[/Энэ хэсэгт 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

7.2.Албан боловсролын агуулга, стандартыг хуульд заасан журмын дагуу тогтооно. Албан бус боловсролын агуулга чөлөөтэй байна.

## **8 дугаар зүйл.Боловсрол эзэмших арга, хэлбэр**

8.1.Иргэн нь боловсролыг албан болон албан бус сургалтаар эзэмшиж болно.

[/Энэ хэсэгт 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

8.2.Тодорхой хугацааны боловсролыг нөхөх, бие даан эзэмших зорилгоор бага, дунд боловсролыг албан бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр олгож болох бөгөөд уг хөтөлбөрийн агуулга, сургалт явуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

## **9 дүгээр зүйл.Боловсролын баримт бичиг**

9.1.Боловсролын баримт бичиг нь тухайн иргэний эзэмшсэн боловсролын агуулгын түвшин, мэргэжлийг гэрчилсэн албан ёсны баталгаа мөн.

9.2.Боловсролын баримт бичиг /гэрчилгээ, үнэмлэх, диплом/-ийг бүрдүүлэх, олгох журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага батална.

9.3.Ерөнхий боловсролын сургууль, албан бус боловсролын төв нь сургалтын баримт бичиг болох сургачийн хувийн хэрэг, ангийн журналыг хөтөлнө.

[/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

9.4.Сургалтын баримт бичгийн загвар, түүнийг хөтлөх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага батална.

[/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

9.5.Гадаад улсын боловсролын баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлэх, багц цаг харилцан тооцоо асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага шийдвэрлэнэ

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **Боловсролын хөтөлбөр, агуулга, стандарт**

[/Энэ бүлгийн гарчигт 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

## **10 дугаар зүйл.Боловсролын хөтөлбөр, агуулга**

[/Энэ зүйлийн гарчигт 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

10.1.Боловсролын агуулга нь суралцагчийн нас, бие, сэтгэхүйн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

10.2.Тухайн шатны боловсролын агуулгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хөтөлбөрөөр зохион байгуулна.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

10.3.Бүх шатны боловсролын хөтөлбөрт монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний төлөвшил, хөгжил, гэр бүл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл, суралцгачийн гүйцэтгэх сайн дурын үйл ажиллагааны төрөл, агуулгыг заавал тусгаж, музей, номын сан, кино зэрэг соёл, урлаг, спортын байгууллагын боломжийг ашиглахаар зохион байгуулна

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

## 11 дүгээр зүйл.Боловсролын агуулгын тувшин, стандарт

11.1.Боловсролын агуулгыг түвшингээр нь сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд гэж ангилна. Боловсролын агуулгыг Сургуулийн өмнөх боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд заасны дагуу тус тус тодорхойлж, тогтооно.

[/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хууль, 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар тус тус нэмэлт, 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

11.2.Боловсролын стандарт нь багшийн мэргэжлийн түвшин, сургалтын орчинд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлно.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

11.3.стандартыг асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6.5-д заасны дагуу баттуулж, улсын бүртгэлд бүртгүүлно:

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ хэсгийг 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

11.4.Сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллага дагаж мөрдөнө..

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн, 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хууль, 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөн найруулсан/](#)

11.5.Сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянан батална."

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

## ГУРАВДУГААР БҮЛЭГ Боловсролын байгууллага

### 12 дугаар зүйл.Боловсролын байгууллага

12.1.Боловсролын зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг боловсролын байгууллага гэнэ.

12.2.Боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө бус, эсхүл ашгийн төлөө байж болно.:

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

12.2.1.ашгийн төлөө бус;

12.2.2.ашгийн төлөө.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

12.3.Төрийн өмчид түшиглэн байгуулах боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө бус байна.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

12.4.Төрийн бус өмчид түшиглэн байгуулах боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө бус болон ашгийн төлөө байна.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

12.5.Ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө боловсролын сургалтын байгууллага байгуулахыг хориглоно.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

### 13 дугаар зүйл.Боловсролын байгууллагын тогтолцоо

13.1.Боловсролын байгууллагын тогтолцоо нь сургалтын, эрдэм шинжилгээ, арга зүйн боловсролын үнэлгээний, мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн болон бусад байгууллагаас бүрдэнэ.

[/Энэ хэсэгт 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хууль, 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар тус тус нэмэлт оруулсан/](#)

13.2.Боловсролын сургалтын байгууллага нь өөрийн үндсэн зорилгодоо нийцсэн судалгаа, туршилт, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэл явуулах боломж, нөхцөлийг бүрдүүлсэн бутэц бүхий төрөл бүрийн хэв шинжтэй байж болно.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

#### **14 дүгээр зүйл.Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллага**

14.1.Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллага нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор байна.

[/Энэ хэсэгт 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

14.2.Бүрэн дунд боловсрол олгох сургалтыг мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага эрхэлж болно.

[/Энэ хэсгийг 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

#### **14<sup>1</sup> дүгээр зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага**

14<sup>1</sup>.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв зэрэг хэв шинжтэй байж болно.

14<sup>1</sup>.2.Политехник коллеж нь техникийн боловсролын сургалт эрхэлдэг байгууллага байна.

[/Энэ зүйлийг 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

#### **15 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллага**

15.1.Дээд боловсролын сургалтын байгууллага нь их сургууль, дээд сургууль, коллеж байна. Их сургууль нь эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн буюу эрдэм шинжилгээ-сургалтын, дээд сургууль нь сургалт-эрдэм шинжилгээний, консерватори /хөгжмийн дээд боловсролын байгууллага/, коллеж нь сургалтын буюу сургалт-үйлдвэрлэлийн хэв шинжтэй байна.

[/Энэ хэсэгт 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

#### **16 дугаар зүйл.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага**

16.1.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бодлого, шийдвэр боловсруулахад судалгааны мэдээллээр хангах, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын асуудлаар байнгын судалгаа, шинжилгээ, арга зүй, сургалтын ажлыг эрхлэх, орон нутгийн боловсролын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, бүх шатны боловсролын байгууллагад сургалт, судалгаа, арга зүйн мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, боловсролын хөгжлийн асуудлаар шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа явуулах, иргэд, олон нийтэд судалгаа, шинжилгээний мэдээллээр үйлчлэх үйл ажиллагааг эрхэлнэ.

[/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

16.2.Аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс нь тухайн нутаг дэвсгэрийн цэцэрлэг, сургуульд удирдлагын болон мэргэжлийн туслалцаа үзүүлэх, боловсролын байгууллагын удирдах ажилтан, багш, иргэнд боловсрол, мэргэжил эзэмших, мэргэшлээ дээшлүүлэх судалгаа, шинжилгээ эрхлэхэд нь туслах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

[/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хууль, 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан/](#)

16.3.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь түшиц цэцэрлэг, сургуультай байж болно.

[/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хууль, 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

16.4.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагын бүтэц, дүрэм болон аймаг, нийслэлийн боловсролын газрын ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага батална.

[/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан, энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

16.5.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь дараах чиглэлээр судалгаа, шинжилгээ, сургалтын ажлыг тасралтгүй эрхлэх байнгын бүтэцтэй байна:

16.5.1.боловсролын стандарт, сургалтын агуулга, хөтөлбөр, сурагчдын мэдлэг, чадвар, дадлын үнэлгээ, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багшийн мэргэжил дээшлүүлэх;

16.5.2.сурх бичгийн агуулга, арга зүй, боловсролын удирдлага, хүүхдийн хүмүүжил, төлөвшил, хөгжил, мэдээлэл, холбооны технологид суурилсан сургалт.

16.6.Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага боловсролын хөгжлийн бодлого болон сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны эрэлт хэрэгцээнд тулгуурлан мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйлчилгээг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

16.7.Багшийн мэргэжил дээшлүүлэх, арга зүйн байгууллагын дүрэм, бүтцийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон тоог санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

## 17 дугаар зүйл.Албан бус боловсролын байгууллага

17.1.Насан туршийн боловсролын сургалт, судалгаа, арга зүйн байгууллага орон нутгийн насан туршийн болон албан бус боловсролын байгууллагыг нэгдсэн удирдлага, бодлого зохицуулалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, энэ чиглэлээр боловсрол олгож байгаа багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах үйл ажиллагааг эрхэлнэ.

[/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хууль, 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөн найруулсан/](#)

17.2.Аймаг, нийслэл, сум, дүүрэгт насан туршийн болон албан бус сургалтыг зохион байгуулах, бие даан суралцагчид туслах үүрэг бүхий албан бус боловсролын төвийг бие даасан хэлбэрээр, эсхүл сургалтын байгууллагыг түшиглүүлэн ажиллуулна.

[/Энэ хэсэгт 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

17.3.Насан туршийн болон албан бус боловсролын сургалт, судалгаа, арга зүйн байгууллагын дүрэм, зохион байгуулалтын бүтцийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

[/Энэ хэсэгт 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт. 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

## 17<sup>1</sup> дүгээр зүйл.Боловсролын үнэлгээний байгууллага

17<sup>1</sup>.1.Боловсролын үнэлгээний байгууллага бүх шатны боловсролын чанарт үнэлгээ, судалгаа хийх, сургалт зохион байгуулах, дээд боловсролын хөтөлбөрт элсэгчдийн элсэлтийн өрөнхий шалгалтыг үндэсний түвшинд хариуцан зохион байгуулах чиг үүрэг бүхий хуулийн этгээд мөн.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

17<sup>1</sup>.2.Боловсролын үнэлгээний байгууллагын бүтэц, дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ зүйлийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

## 18 дугаар зүйл.Сургалтын бусад байгууллага

18.1.Сургуулиас гадуурх сургалтын ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрийн үйл ажиллагааны чиглэлээр нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, хууль зүй, байгаль орчин, гоо зүй, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, гэр булийн болон ахуйн хүрээний асуудлаар тусгай хөтөлбөрийн дагуу хүүхэд, насанд хүрэгчдэд боловсрол эзэмшүүлэх, боловсрол, мэргэшлээ дээшлүүлэхэд нь туслалцаа, өдөр өнжүүлэх үйлчилгээ үзүүлж болно.

[/Энэ хэсэгт 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

18.2.Иргэнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зайлшгүй шаардагдах мэргэжил эзэмшүүлэх, мэргэшил дээшлүүлэх сургалтыг бүх шатны сургууль, бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэн эрхэлж болно.

18.3.Аж ахуйн нэгж, байгууллага боловсролын сургалтын болон сургалтын бусад байгууллагыг хууль тогтоомжид заасны дагуу байгуулан ажиллуулж болно.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

18.4.Шашны сургуульд суралцагчид суурь боловсрол эзэмшүүлэх харилцааг энэ хууль болон Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулна.

18.5.Энэ хуулийн 3.1.19-т заасан үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

## 19 дүгээр зүйл.Боловсролын сургалтын байгууллага байгуулах

19.1.Боловсролын сургалтын байгууллагыг зориулалтын барилга, байгууламж, техник хэрэгсэл, ном, сурах бичиг, багшлах боловсон хүчинээр хангагдсан нөхцөлд өмчийн аль ч хэлбэрт үндэслэн байгуулж болно.

19.2.Боловсролын сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн байгуулагдсанд тооцно.

[/Энэ хэсэгт 2015 оны 1 дугээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

## **20 дугаар зүйл.Зөвшөөрөл олгох байгууллага**

[/Энэ зүйлийн гарчигт "Тусгай зөвшөөрөл" гэснийг "Зөвшөөрөл" гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дугээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө./](#)

20.1.Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасны дагуу их сургууль, дээд сургууль, коллежид, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт аймаг, нийслэлийн боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус олгоно.

[/Энэ хэсэгт "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дугээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө./](#)

[/Энэ хэсэгт "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.7.1, 15.7.2, 15.7.4, 15.7.8, 15.7.9, 16.2.4, 16.3.3-т заасны дагуу" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасны дагуу" гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дугээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө./](#)

[/Энэ хэсэгт 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хууль, 2011 оны 1 дугээр сарын 20-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт, 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт, 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хууль, 2015 оны 1 дугээр сарын 29-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

20.2.Олон улсын хөтөлберийн сургалттай ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын лаборатори сургууль, их сургууль, дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу байгуулах хамтарсан сургууль болон гадаадын хөрөнгө оруулалттай цэцэрлэг, сургууль байгуулах зөвшөөрлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

[/Энэ хэсэгт "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дугээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө./](#)

[/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн, энэ хэсэгт 2015 оны 1 дугээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ хэсгийг 2016 оны 4 дугээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

## **21 дугээр зүйл.Зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг**

[/Энэ зүйлийн гарчигт "Тусгай зөвшөөрөл" гэснийг "Зөвшөөрөл" гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дугээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө./](#)

21.1.Боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулагч нь зөвшөөрөл авахдаа Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т зааснаас гадна дараахь баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа эхлэхээс зургаагаас доошгүй сарын өмнө зөвшөөрөл олгох байгууллагад ирүүлнэ:

[/Энэ хэсэгт "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дугээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө./](#)

[/Энэ хэсэгт "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т" гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дугээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө./](#)

21.1.1.боловсролын сургалтын байгууллага байгуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, өргөдөл, дүрэм, үүсгэн байгуулах тухай гэрээний аль нэг;

[/Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

21.1.2.боловсролын сургалтын байгууллага байгуулах үндэслэл, тооцоо бүхий танилцуулга;

21.1.3.сургалтын төлөвлөгөө;

21.1.4.багшлах боловсон хүчиний хангамж, бүрэлдэхүүн, боловсролын түвшин, зэрэг, цолны судалгаа;

21.1.5.сургалт явуулах барилга байгууламж, техник хэрэгсэл, ном, сурах бичиг зэрэг сургалтын хэрэглэгдэхүүний баталгаа;

21.1.6.санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, түүний баталгаа;

21.1.7.үүсгэн байгуулагчаас сургалтын байгууллагын мэдэлд шилжүүлэх хөрөнгө /биет болон мөнгөн/-ийн жагсаалт, хэмжээ, баталгаа;

21.1.8.байгууллагын эзэмшил газрын зөвшөөрөл.

21.2.Боловсролын сургалтын байгууллага шинэ мэргэжлээр сургалт явуулах, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх зөвшөөрөл авахдаа Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т заасан баримт бичгээс гадна энэ хуулийн 21.1.3-21.1.7-д

заасан баримт бичиг, сургалт явуулах үндэслэл, тооцоог сургалтын үйл ажиллагаа эхлэхээс таваас доошгүй сарын өмнө зөвшөөрөл олгох байгууллагад ирүүлнэ.

[/Энэ хэсгийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө./](#)

21.3.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

21.4.Энэ хуулийн 21.1.1-21.1.7-д заасан баримт бичигт тавигдах шаардлага, загварыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

21.5.Боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

21.6.Боловсролын сургалтын байгууллага шинэ хөтөлбөрөөр сургалт эрхлэхийн өмнө Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагаар урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэнэ

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

## 22 дугаар зүйл.Зөвшөөрөл олгох, улсын бүртгэлд бүртгэх

[/Энэ зүйлийн гарчигт "Тусгай зөвшөөрөл" гэснийг "Зөвшөөрөл" гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө./](#)

[/Энэ зүйлийн гарчигт 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

22.1.Боловсролын сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгэх асуудлыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

22.2.Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дараах журмаар олгоно:

[/Энэ хэсэгт "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө./](#)

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

22.2.1.зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага энэ хуулийн 21.1-д заасан баримт бичгийг үүсгэн байгуулагчаас хүлээн авснаас хойш ажлын 21 өдрийн дотор боловсролын сургалтын байгууллага байгуулах урьдчилсан зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх;

[/Энэ заалтад "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө./](#)

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

22.2.2.урьдчилсан зөвшөөрөл олгох тухай эрх бүхий байгууллагыг шийдвэр гарсан өдрөөс үүсгэн байгуулагч зөвшөөрлийн шаардлагыг хангах талаар санал болгосон нөхцөлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

[/Энэ заалтад "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө./](#)

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

22.2.3.үүсгэн байгуулагч зөвшөөрлийн шаардлагыг бүрэн хангасны дараа холбогдох баримт бичгийг өргөдлийн хамт эрх бүхий байгууллагад ирүүлэх;

[/Энэ заалтад "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө./](#)

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

22.2.4.зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор эрх бүхий байгууллага төрийн захиргааны болон боловсролын байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий шинжээчийн хэсэг томилж, магадлан шинжилгээ хийлгэх бөгөөд магадлан шинжилгээ хийлгэхтэй холбогдсон зардлыг үүсгэн байгуулагч хариуцах;

[/Энэ заалтад "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө./](#)

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

22.2.5.шинжээчийн хэсэг томилогдоноосоо хойш 30 хоногт багтаан баримт бичигт магадлан шинжилгээ хийж, газар дээр нь танилцан дүгнэлт гаргах;

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

22.2.6.энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан байгууллага шинжээчийн хэсгийн дүгнэлтийг үндэслэн зөвшөөрөлт олгох эсэх талаар шийдвэр гаргаж, үүсгэн байгуулагчид мэдэгдэх, тусгай зөвшөөрлийг олго.

/Энэ заалтад "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/

22.3.Боловсролын сургалтын байгууллага үүсгэн байгуулах гэрээ, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан, оршин байгаа газраа өөрчилсөн бол энэ тухайгаа улсын бүртгэлийн байгууллагад ажлын 15 өдрийн дотор бичгээр мэдэгдэж, улсын бүртгэлд өөрчлөлт оруулна.

/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/

22.4.Улсын бүртгэлийн байгууллага боловсролын сургалтын байгууллагыг сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлд үндэслэн төрийн өмчийн, ашгийн төлөө бус, ашгийн төлөө гэсэн ангиллаар, энэ хуулийн 14, 14<sup>1</sup>, 15 дугаар зүйлд заасан хэв шинжээр нь нэрлэж бүртгэнэ

/Энэ хэсэгт "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ зүйлийг 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

## 23 дугаар зүйл.Зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

/Энэ зүйлийн гарчигт "Тусгай зөвшөөрлийн" гэснийг "Зөвшөөрлийн" гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

23.1.Зөвшөөрлийг 5 жилээс доошгүй хугацаагаар олгоно.

/Энэ хэсэгт "Тусгай зөвшөөрлийг" гэснийг "Зөвшөөрлийг" гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

23.2.Зөвшөөрлийн хугацааг он, сар, өдрөөр тодорхойлох бөгөөд тухайн сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн тоолно.

/Энэ хэсэгт "Тусгай зөвшөөрлийн" гэснийг "Зөвшөөрлийн" гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

23.3.Хугацаа сунгуулах тухай өргөдлийг зөвшөөрлийн хугацаа дуусахаас гурван сарын өмнө гаргана.

/Энэ хэсэгт "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

23.4.Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1-д заасан нөхцөл байдал илрээгүй бол зөвшөөрөл эзэмшигчийн өргөдлийг үндэслэн 14 хоногийн дотор зөвшөөрлийн хугацааг сунгана.

/Энэ хэсэгт "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

/Энэ хэсэгт "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1-д заасан" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1-д заасан" гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

## 24 дүгээр зүйл.Зөвшөөрлийг хүчингүй болгох

/Энэ зүйлийн гарчигт "Тусгай зөвшөөрлийг" гэснийг "Зөвшөөрлийг" гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

24.1.Зөвшөөрөл олгосон байгууллага нь Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1-д зааснаас гадна дараах үндэслэлээр түүнийг хүчингүй болгоно:

/Энэ хэсэгт "Тусгай зөвшөөрөл" гэснийг "Зөвшөөрөл" гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

/Энэ хэсэгт "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1-д зааснаас" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1-д зааснаас" гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

24.1.1.мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтээр стандарт зөрчсөн, эсхүл сургалт эрхлэх зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа хангаагүй болох нь тогтоогсон;

/Энэ заалтад "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан. Энэ заалтад 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

24.1.2.нийгэм, иргэний эрх ашиг, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй сургалт зохион байгуулсан нь холбогдох мэргэжлийн байгууллагаар тогтоогдсон;

24.1.3.улсын бүртгэлд бүртгүүлсэн буюу зөвшөөрөл авснаас хойш зургаан сарын дотор үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй;  
[/Энэ заалтад "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

24.1.4.боловсролын сургалтын байгууллагыг бусад байгууллагатай нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулсан;

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

24.1.5.хуульд заасан бусад үндэслэл.

[/Энэ заалтын дугаарт 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

## 25 дугаар зүйл.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах

25.1.Боловсролын сургалтын байгууллагыг дараах тохиолдолд татан буулгана:

25.1.1.ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллага бол тухайн боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн шийдвэрээр, ашгийн төлөө боловсролын сургалтын байгууллага бол хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр;

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

25.1.2.зөвшөөрлийг хүчингүй болгосон;

[/Энэ заалтад "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

25.1.3.татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан;

25.1.4.хуульд заасан бусад үндэслэл.

25.2.Боловсролын сургалтын байгууллагыг энэ хуулийн 25.1.1-д заасны дагуу татан буулгах шийдвэр гарахаас 2 сарын өмнө тухайн боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах ажлын төлөвлөгөө, авах арга хэмжээний талаархи саналаа холбогдох тооцоо, судалгааны хамт боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага уг саналыг судлан дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

25.3.Тухайн боловсролын сургалтын байгууллагыг бүртгэх байгууллага улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцно.

25.4.Боловсролын сургалтын байгууллага татан буугдсан болон суралцагчид учирсан хохирлыг арилгуулахтай холбоотойгоор үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ.

25.5.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгахтай холбогдон үүсэх эд хөрөнгийн харилцааг иргэний хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

25.6.Энэ хуулийн 25.2-т заасныг хэрэгжүүлэхтэй холбоотой дүгнэлт гаргах аргачлал, журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

## 26 дугаар зүйл.Боловсролын магадлан итгэмжлэл

26.1.Боловсролын магадлан итгэмжлэл нь боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарт хараат бус үнэлгээ хийж, ахиц дэвшилж дэмжин, мэргэжлийн хүрээнд хүлээн зөвшөөрөх ажиллагаа мөн.

[/Энэ хэсэгт 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

26.2.Боловсролын магадлан итгэмжлэлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон, ашгийн төлөө бус байгууллага хэрэгжүүлэх бөгөөд тус байгууллага нь үйл ажиллагааныхаа үр дүнг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлagnана.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

26.3.Магадлан итгэмжлэх байгууллагын дүрмийг Засгийн газар батална.

26.4.Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын удирдах зөвлөл төр, олон нийт, суралцагчийн төлөөллөөс бүрдэнэ.

[/Энэ хэсэгт 2003 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан, энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

26.5.Боловсролын сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх байгууллага нь Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний

зөвлөл байна.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

26.6.Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл магадлан итгэмжлэх шалгуур, журмыг тогтоох, сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийх байгууллагыг бүртгэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

26.7.Төрөөс боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлд бусад магадлан итгэмжлэх байгууллагыг удирдамж, нэгдсэн зохицуултаар хангахад дэмжлэг үзүүлнэ.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

26.8.Монгол Улсад магадлан итгэмжлэх үйл ажиллагаа явуулах гадаадын байгууллагыг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл бүртгэж, зөвшөөрөл олгоно.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ** **Боловсролын удирдлага**

### **27 дугаар зүйл.Боловсролын удирдлагын тогтолцоо**

27.1.Боловсролын удирдлагын тогтолцоо нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын газар, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн болон боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлагаас бүрдэнэ.

[/Энэ хэсгийг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

27.2.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь аймаг, нийслэлд боловсролын газар, нийслэлийн дүүрэгт боловсролын хэлтэс байна.

[/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

27.3.Аймаг, нийслэлийн боловсролын газрын дэргэд тухайн нутаг дэвсгэрт явуулах боловсролын үйл ажиллагааны бодлого, хөгжлийн төлөвлөлтийн асуудлаар зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

### **28 дугаар зүйл.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

28.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.1.1.боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах;

28.1.2.боловсролын салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохтой холбоотой санал боловсруулах, салбарынхаа холбогдох тесөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон шаардлагатай дүрэм, журам, заавар, аргачлал боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тооцох;

[/Энэ хэсгийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан, энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

28.1.3.мэргэжлийн анхан, дунд, дээд боловсролын мэргэжлийн чиглэлийг тогтоох;

28.1.4.бүх шатны боловсролын стандарт, норм, нормативыг Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулах;

[/Энэ заалтад 2002 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хууль, 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

28.1.5.иргэнд албан албан бус сургалтаар боловсрол эзэмшигүүлэх, мэргэжил олгох, түүний боловсрол, мэргэшлийг дээшлүүлэх талаар бусад байгууллагаас зохиож байгаа ажлыг төрийн захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, зохицуулах;

28.1.6.удирдах ажилтан, багшийг нэгдсэн бодлого, тодорхой чиглэлээр бэлтгэх, давтан сургах, тэдний нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, энэ талаар гарсан шийдвэрийн биенэлтийг хангах;

28.1.7.цэцэрлэг, бүх шатны сургууль, боловсролын эрдэм шинжилгээ, мэргэжил, арга зүйн байгууллагыг зориулалтын барилга байгууламж, техник хэрэгсэл, тооног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн, ном, сурх бичгээр хангах ажлыг холбогдох

байгууллагатай хамтран зохион байгуулах;

[/Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

28.1.8.оловсролын хөтөлбөр, норм, нормативыг хэрхэн хэрэгжүүлж байгааг тогтоох зорилгоор боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн чанарт үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, хүүхдийн хөгжлийн ахиц дэвшилийг дэмжих, баталгаажуулах чиглэлээр мэргэжлийн удирдлагаар хангах;

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ заалтад 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ заалтыг 2016 оны 4 дугээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

28.1.9.терийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

28.1.10.оловсролын асуудлаар гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах, үр өгөөжийг дээшлүүлэх;

28.1.11.гадаадын их сургууль, дээд сургууль, коллеж, эрдэм шинжилгээний байгууллага, сургалтын төвд хувийн болон байгууллагын зардлаар суралцах хүнд зуучлах, мэдээллийн нэгдсэн бүртгэлд хамруулах, хяналт тавих, холбогдох журмыг баталж мөрдүүлэх;

[/Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

28.1.12.оловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага, албан бус боловсролын сургалт, судалгаа, арга зүйн байгууллага, төрийн өмчит их сургууль, дээд сургууль, коллеж, төрийн өмчийн олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль болон ерөнхий боловсролын лаборатори сургуулийн захирлыг сонгон шалгаруулалтын дунг үндэслэн томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх;

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ заалтад 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хууль, 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хууль, 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хууль, 2016 оны 4 дугээр сарын 14-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт, 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/](#)

28.1.13.аймаг, нийслэлийн боловсролын газрыг мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах;

[/Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

28.1.14.суралцагчид хөнгөлөлттэй зээл олгох, буцалтгүй тусламж үзүүлэх, сургалтын төлбөрийг төр хариуцах асуудлыг Засгийн газраас баталсан журмын дагуу шийдвэрлэх;

[/Энэ заалтыг 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

28.1.15.оловсролын үйлчилгээ суралцагчийн хэрэгцээ, шаардлагад нийцэж, тэдний нэр төр, эрх чөлөөг хангаж байгаа эсэхэд хяналт тавих үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах;

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

28.1.16.орон нутгийн ажиллах хүчиний хэрэгцээнд үндэслэн дээд боловсролын байгууллагад зохих журмын дагуу элссэн иргэдээс Боловсролын зээлийн сангаас буцалтгүй тусламжаар суралцуулах оюутны тоог жил бүр аймаг, нийслэлээр тогтоож, гэрээний үндсэн дээр суралцуулах журам баталж хэрэгжүүлэх;

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн, энэ заалтад 2016 оны 9 дугээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

28.1.17.энэ хуулийн 28.1.16-д заасан гэрээний үндсэн дээр дээд боловсрол эзэмшсэн багш, боловсрол, соёл, эрдэм шинжилгээний ажилтанг орон нутагт томилон ажиллуулах;

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

28.1.18.оловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтан, багш, оюутан, сурагчдын ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх;

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

28.1.19.терийн өмчит их сургууль, дээд сургууль, коллеж, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын алба, насан туршийн боловсролын сургалт, арга зүйн байгууллага, төрийн өмчийн олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн захирал /дарга/-ын ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлэх;

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн, энэ заалтад 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хууль, 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан, энэ заалтыг 2016 оны 4 дугээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

28.1.20.оловсролын стандартыг хэвлэх, түгээх ажлыг зохион байгуулах;

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

28.1.21.[/Энэ заалтыг 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмсэн, 2016 оны 4 дугээр сарын 14-ний өдрийн хуулиар хүчингүй](#)

28.1.22.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын байгууллагын багш, ажилтны ажлыг үнэлэх, дүгнэх, багшлах эрх олгох, арга зүйч, багш, сургалтын менежерийн мэргэжлийн зэрэг олгох, хасах журмыг батлах бөгөөд албан тушаал өөрчлөгдхөх тохиолдолд цэцэрлэг, сургуулийн удирдах албан тушаал эрхэлж байгаа багшийн мэргэжлийн зэрэг хэвээр хадгалагдах;

[/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн. 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

28.1.23.төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам батлах;

[/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

28.1.24.сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам батлах;

[/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

28.1.25.төрийн өмчийн олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль болон ерөнхий боловсролын лаборатори сургуулийн тусгай арга хэмжээ, хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтыг хэрэгжүүлэх журам боловсруулж батлах;

[/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

28.1.26.гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, соёл, ёс заншил зааж сургахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

28.1.27.ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, албан тушаалтанд тавих нийтлэг шаардлага, ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт батлах;

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

28.1.28.энэ хууль болон бусад хуульд заасан бүрэн эрх.

[/Энэ заалтын дугаарт 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ заалтын дугаарт 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хууль. 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хууль. 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хууль. 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

[28.2./Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмсэн. 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

28.3.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоол, хүнсний эрүүл, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн стандарт, норм, нормативыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, эрх бүхий байгууллага батална.

[/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

28.4.Сургуулийн нийгмийн ажилтанд мэргэжлийн зэрэг, нэмэгдэл хөлс олгох журмыг Засгийн газар батална.

[/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

## **28<sup>1</sup> дугаар зүйл.Аймаг, нийслэлийн боловсролын газар**

28<sup>1</sup>.1.Аймаг, нийслэлийн боловсролын газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28<sup>1</sup>.1.1.боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах;

28<sup>1</sup>.1.2.ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргад санал болгох;

[/Энэ заалтад "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

28<sup>1</sup>.1.3.багш, суралцагчийн хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

28<sup>1</sup>.1.4.боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх;

[/Энэ заалтад 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

- 28<sup>1</sup>.1.5.боловсролын тайлан, мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад гаргаж өгөх;
- 28<sup>1</sup>.1.6.орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох;
- 28<sup>1</sup>.1.7.орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;
- 28<sup>1</sup>.1.8.төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

28<sup>1</sup>.1.9.аймаг, дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дүрэмт хувцасны нэгдсэн загварыг батлах.

[/Энэ заалт таг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

28<sup>1</sup>.1.10.өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах.

[/Энэ заалт таг 2016 оны 4 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

28<sup>1</sup>.2.Нийслэлийн дүүргийн боловсролын хэлтсийн хэрэгжүүлэх чиг үүргийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн нийслэлийн Засаг дарга тогтооно.

28<sup>1</sup>.3.Нийслэлийн боловсролын газар нь энэ хуулийн 28<sup>1</sup>.1-д заасан чиг үүргээ нийслэлийн дүүргийн боловсролын хэлтсээр дамжуулан хэрэгжүүлж болно.

## **28<sup>2</sup> дугаар зүйл.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага**

28<sup>2</sup>.1.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

28<sup>2</sup>.1.1.боловсролын болон холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

28<sup>2</sup>.1.2.аймаг, нийслэлийн боловсролын газар болон боловсролын сургалтын байгууллагыг мэргэжил, арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах;

28<sup>2</sup>.1.3.гамшигийн улмаас хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоох, хэлбэр өөрчлөх тохиолдолд сургалтын тасралтгүй байдлыг хангах хариу арга хэмжээг авах нэгдсэн зохицуулалт хийх;

28<sup>2</sup>.1.4.хуульд заасан бусад чиг үүрэг.

[/Энэ зүйлийг 2021 оны 11 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

## **29 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх**

29.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.1.1.боловсролын асуудлаар тухайн шатны ба доод шатны Засаг даргын тайлан хэлэлцэж, чиглэл өгөх;

29.1.2.орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих;

[/Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

29.1.3./Энэ заалтыг 2003 оны 1 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон/

29.1.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

## **30 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх**

30.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.1.1./[Энэ заалт таг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болсон тооцсон/](#)

30.1.2.иргэнд суурь боловсрол эзэмшүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэжил эзэмшүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;

30.1.3.орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэх;

[/Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

30.1.4.өөрийн орлогоо нэмэгдүүлэхэд нь боловсролын байгууллагад дэмжлэг үзүүлэх, тэдгээрийг хичээлийн болон дотуур байр, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурах бичгээр хангах ажлыг зохион байгуулах;

[/Энэ заалтад 2003 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

30.1.5.төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

30.1.6.энэ хууль болон Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох;

[/Энэ заалтад "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ заалтад "Аж ахуйн уйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" гэснийг "Зөвшөөрлийн тухай" гэж 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт, 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

30.1.7.[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

30.1.8.[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

30.1.9.[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

30.1.10.[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

30.1.11.аймаг, нийслэлийн боловсролын газрын даргыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрснөөр томилох, чөлөөлөх;

[/Энэ заалтад 2003 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

30.1.12.үндэсний цөөнхийн боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

30.1.13.цэцэрлэгийг зориулалтын барилга байгууламжаар, ерөнхий боловсролын сургуулийг хичээлийн болон дотуур байраар хангах, дотуур байрны хүүхдийн хоол хүнсний хангамжийг зохих журмын дагуу шийдвэрлэх;

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

30.1.14.орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын захирлыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас нь чөлөөлөх;

[/Энэ заалтыг 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

30.1.15.аймаг, нийслэлийн боловсролын газрын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн оронхий боловсролын сургуулийн захираал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох, тэдгээрийг үр дунгийн гэрээний хэрэгжилт бөлөн аймаг, нийслэлийн боловсролын газрын саналыг үндэслэн чөлөөлөх;

[/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн, энэ заалтыг 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

30.1.16.хуульд заасан бусад бүрэн эрх.

[/Энэ заалтын дугаарт 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хууль, 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хууль, 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

## 31 дүгээр зүйл.Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

31.1.Сум, дүүргийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

31.1.1.боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

31.1.2.хүүхдэд сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, иргэнд суурь боловсрол нөхөн эзэмшүүлэх ажлыг захиргааны удирдлагаар хангах;

31.1.3.[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

31.1.4.[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

31.1.5./[Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

31.1.6./[Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

31.1.7.өөрийн орлогоо нэмэгдүүлэхэд боловсролын байгууллагад дэмжлэг үзүүлэх;

[/Энэ заалтад 2003 оны 1 дугээр сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

31.1.8./[Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

31.1.9.төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

31.1.10./[Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

31.1.11./[Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

31.1.12.аймаг, нийслэлийн боловсролын газрын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн өрөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох, тэдгээрийг үр дүнгийн гэрээний хэрэгжилт болон аймаг, нийслэлийн боловсролын газрын саналыг үндэслэн чөлөөлэх;

[/Энэ заалтыг 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

31.1.13.хуульд заасан бусад бүрэн эрх.

[/Энэ заалтын дугаарт 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

31.2.Дүүргийн Засаг дарга тухайн дүүргийн боловсролын хэлтсийн даргыг нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлийн сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн нийслэлийн боловсролын газрын даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

[/Энэ хэсгийг 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

## 32 дугаар зүйл.Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх

32.1.Баг, хорооны Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.1.1.сургуулийн өмнөх болон суурь боловсрол эзэмшүүлэх сургалтад харьяа айл өрхийн хүүхдийг хамруулах;

32.1.2.иргэдийн боловсрол эзэмшсэн байдалд судалгаа хийж, шаардлагатай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

32.1.3.суурь боловсрол эзэмшээгүй иргэнд нөхөн эзэмшүүлэх ажил зохион байгуулах.

## 33 дугаар зүйл.Боловсролын сургалтын байгууллагын удирдлага

33.1.Өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулагч буюу түүний эрх олгосон этгээдийн томилсон захирал, эрхлэгч удирдана.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

33.2.Захирал, эрхлэгч нь Сургуулийн өмнөх боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай болон Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

[/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

33.3.Боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч нь орон тооны байна.

## 34 дүгээр зүйл.Боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлага

34.1.Боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлагыг өрөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт сургуулийн болон цэцэрлэгийн зөвлөл, их сургууль, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, төрийн өмчийн олон улсын хөтөлбэрийн сургалттай өрөнхий боловсролын сургууль, улсын хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг өрөнхий боловсролын сургуульд, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу байгуулсан боловсролын сургалтын байгууллагад удирдах зөвлөл тус тус хэрэгжүүлнэ. Сургалт эрхлэх чиглэл, нутаг дэвсгэрийн байршлыг харгалзан сургууль, цэцэрлэгийн зөвлөл болон удирдах зөвлөлийг дундын хэлбэрээр байгуулж болно.

[/Энэ хэсэгт 2006 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт, 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

34.2.Цэрэг, цагдаагийн дээд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад энэ хуулийн 34.1-д заасан заалт хамаарахгүй.

34.3./Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн, 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

34.4.Энэ хуулийн 34.1-д заасан зөвлөлийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дурмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

### 35 дугаар зүйл.Сургууль, цэцэрлэгийн зөвлөл

35.1.Сургууль, цэцэрлэгийн зөвлөл нь багш, ажилтан, сургач, эцэг, эх, бусад байгууллагын төлөөлөлтэй байна. 9-11 гишүүнтэй сургууль, цэцэрлэгийн зөвлөлийг 3 жилийн хугацаагаар сонгоно.

35.2.Сургууль, цэцэрлэгийн зөвлөлд орох багш, ажилтан, сургач, эцэг, эхийн төлөөллийг тэдгээрийн хамт олны хурлаас тус тус сонгоно.

35.3.Сургууль, цэцэрлэгийн зөвлөлд орох бусад байгууллагын төлөөллийг үүсгэн байгуулагчийн саналыг үндэслэн сургууль, цэцэрлэгийн нийт ажилтны хурлаас сонгоно.

35.4.Сургууль, цэцэрлэгийн зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

35.4.1.сургууль, цэцэрлэгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам батлах, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

35.4.2.сургууль, цэцэрлэгийн дэг журам, дотоод зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох;

35.4.3.сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;

35.4.4.сургалтын чанар, хүүхэд төлөвшүүлэх, хамгаалах, хөгжүүлэх ажлын үр дүн, түвшинг сайжруулах талаар сургууль, цэцэрлэгийн удирдлага болон үүсгэн байгуулагчид санал тавих;

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

35.4.5.захирал, эрхлэгчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, дэмжлэг үзүүлэх;

35.4.6.багш, сургач, ажилтны эрх ашгийг хамгаалах;

35.4.7./Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

35.4.8.сургалтын төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу тогтоох.

[/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

35.4.9.сургууль, цэцэрлэгийн хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд хэрэгжүүлэх арга хэмжээ, төслийг эрэмбэлэх, шийдвэрлүүлэх санал өгөх, зайлшгүй нөхцөл байдлын улмаас хүүхдээ 6 наснаас нь сургуульд элсүүлэх боломжгүй талаар малчин эцэг, эхийн гаргасан хүсэлтийг үндэслэж шийдвэрлэх;

[/Энэ заалтад 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

35.4.10.сургууль, цэцэрлэгийн батлагдсан төсөв, сангийн зарцуулалтад хяналт тавих, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланда хийсэн аудитын дүгнэлттэй танилцах, мэдээлэх;

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

35.4.11.сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагааны тайланг гаргаж, хамт олны хуралд тайлагнах.

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

35.5./Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

35.6./Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

35.7.Энэ хуулийн 35.4.8 дахь заалт нь зөвхөн төрийн өмчийн бус сургууль, цэцэрлэгийн зөвлөлд хамаарна.

[/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

### 36 дугаар зүйл.Удирдах зөвлөл

36.1.Удирдах зөвлөл нь үүсгэн байгуулагч, багш, суралцагч, төгсөгчийн төлөөлөлтэй байна.

[/Энэ хэсэгт 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

36.2.Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 51-60 хувь нь үүсгэн байгуулагчийн төлөөлөл байна. Удирдах зөвлөлд орох үүсгэн байгуулагчийн төлөөллийг үүсгэн байгуулагчийн шийдвэрээр болон түүний эрх шилжүүлснээр томилно.

[/Энэ хэсэгт 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

36.3.Удирдах зөвлөлд орох багш, суралцагчийн төлөөллийг хамт олны хурлаас сонгоно.

#### 36.4./Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

36.5.Удирдах зөвлөлийн гишүүнийг турван жилийн хугацаагаар сонгох буюу томилно. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны нэгийг жил бүр өөрчилж болно.

36.6.Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Удирдах зөвлөл бүрэн эрхийн хугацаанд жилд хоёроос доошгүй удаа хуралдаж, эзлжит бус хурлыг үүсгэн байгуулагч, зөвлөлийн дарга буюу гишүүдийн 1/3-ээс доошгүйн саналаар хуралдуулна. Захирал тодорхой асуудлаар удирдах зөвлөлийг хуралдуулах саналаа зөвлөлийн даргад тавьж болно.

#### /Энэ хэсгийн дугаарыг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн/

36.7.Удирдах зөвлөл олонхийн саналаар шийдвэр гаргана. Зөвлөлийн даргыг удирдах зөвлөлөөс сонгоно.

#### /Энэ хэсгийн дугаарыг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн/

36.8.Удирдах зөвлөл үйл ажиллагаанд туслах үүрэг бүхий комисс, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

#### /Энэ хэсгийн дугаарыг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн/

36.9.Удирдах зөвлөлд орсон үүсгэн байгуулагчийн төлөөлөл нь түүний бодлого, чиг үүргийг хэрэгжүүлнэ.

#### /Энэ хэсгийн дугаарыг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн/

36.10.Удирдах зөвлөлийн даргыг үүргээ хангалтгүй биелүүлсэн, хууль тогтоомж зөрчсөн нь нотлогдсон, өөрөө чөлөөлөгдхэйг хүссэн үндэслэлээр хугацаанаас өмнө өөрчилж болно.

#### /Энэ хэсгийн дугаарыг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн/

36.11.Үүсгэн байгуулагч удирдах зөвлөл, түүний гишүүнийг хангалтгүй ажилласан гэж үзвэл өөрийн төлөөллөө эгүүлэн татах, бусад гишүүний талаар сонгосон хамт олонд нь мэдэгдэх эрхтэй.

#### /Энэ хэсгийн дугаарыг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн/

36.12.Удирдах зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

#### /Энэ хэсгийн дугаарыг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн/

36.12.1.холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсролын байгууллагыг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, дүрмийг батлах, өөрчлөх;

#### /Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

#### /Энэ заалтын дугаарыг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн/

36.12.2.сургуулийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалингийн нийт хэмжээг тогтоох.

/Энэ заалтын орон тоо, цалингийн нийт хэмжээг тогтоохтой холбогдох хэсэг нь төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагад хамаарахгүй/;

#### /Энэ заалтад 2003 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан, энэ заалтын дугаарыг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн./

36.12.3.хөрөнгө оруулалт, жилийн төсвийн хуваарилалтыг баталж, зарцуулалтад хяналт тавих, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хандив авах журам тогтоох;

#### /Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан, энэ заалтын дугаарыг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн./

36.12.4.сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу тогтоох;

#### /Энэ заалтын дугаарыг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн/

36.12.5.сургуулийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;

#### /Энэ заалтын дугаарыг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн/

36.12.6.удирдах зөвлөлийн үйл ажиллагааны жилийн тайлан гаргаж үүсгэн байгуулагчид өгөх.

#### /Энэ заалтын дугаарыг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн/

36.13.Удирдах зөвлөл нь захирлыг томилох, чөлөөлөх саналыг үүсгэн байгуулагчид тавьж болно.

36.14.[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн. 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

36.15.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн төлөөллийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиар зохицуулна.

[/Энэ хэсгиг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн. Энэ хэсгийн дугаарыг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн/](#)

[/Энэ зүйлийг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

### **37 дугаар зүйл.Боловсролын хяналт**

37.1.Боловсролын хяналтыг хяналт-шинжилгээ, тандалт, судалгаа хийх хэлбэрээр хэрэгжүүлнэ.

37.2.Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавина.

[/Энэ хэсэгт "тусгай" гэснийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ зүйлийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

### **ТАВДУГААР БҮЛЭГ Боловсролын эдийн засаг**

### **38 дугаар зүйл.Боловсролын төлөвлөлт, мэдээлэл**

38.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага орон нутгийн захиргааны болон холбогдох бусад байгууллагын оролцоотойгоор боловсролын хөгжлийн ойрын болон хэтийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

38.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан төлөвлөгөө, арга зүйг үндэслэн аймаг, нийслэл, сум, дүүрэг боловсролын ойрын болон хэтийн төлөвлөгөөтэй байна.

38.3.Цэцэрлэг, сургууль, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага тогтоосон норм, нормативыг үндэслэн зорилтолт төлөвлөгөөтэй ажиллана.

38.4.Өмчийн аль ч хэлбэрийн боловсролын байгууллага хууль тогтоомжид заасан мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв гаргаж боловсролын дээд шатны байгууллагад тайлагнана.

### **39 дүгээр зүйл.Боловсролын санхүүжилт**

[/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан. Энэ хэсгийг 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

39.2.Боловсролын байгууллага нь улсын төсөв, орон нутгийн төсөв, хөрөнгө оруулалт, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс оруулах сургалтын төлбөр, дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулсан хандив, зээл, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг санхүүгийн эх үүсвэртэй байна.

[/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2006 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

39.3.Боловсролын сургалтын байгууллага санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх, багш, ажилтан, суралцагчийн нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжид нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж болох бөгөөд түүнээс олсон орлогоо энэ хуульд заасан зориулалтын дагуу захираан зарцуулах эрхийг боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч эдэлнэ.

39.4.Боловсролын байгууллагын өөрийн орлогын хэмжээтэй холбоотойгоор улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг баагасгахыг хориглоно.

[/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

39.5.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын газар нь улсын төсөв, судалгааны ажлын төслийн зардлаар санхүүжнэ.

[/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хууль. 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

39.6.Орой, эчнээ, албан бус хэлбэрээр иргэдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвээс санхүүжүүлнэ.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

39.7.Орон нутгийг боловсон хүчинээр хангах, чухал хэрэгцээтэй мэргэжилтэн бэлтгэх, суралцагчийн авьяасыг дэмжих, орлого баатай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боловсрол эзэмшихэд зориулж сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох бөгөөд тэдгээрийг олгох журмыг Засгийн газар батална.

[/Энэ хэсэгт 2003 оны 1 дугээр сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ хэсгийг 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

39.8.Олон нийтийн үүсгэл санаачилгаар аймаг, нийслэл, сум, дүүрэгт боловсрол хөгжүүлэх сан байгуулж болно.

39.9.Боловсролд зориулсан төсвийн болон сангийн хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

39.10.Ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллага үүсгэн байгуулагчаас өөрт нь нийлүүлсэн болон тухайн сургалтын байгууллагын үйл ажиллагааных нь явцад бий болсон хөрөнгийг өөрийн үндсэн үйл ажиллагааны зорилго, дүрэмд нийцүүлэн зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах үүрэгтэй.

[/Энэ хэсэгт 2016 оны 4 дугээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

39.11.Сургалтын байгууллага нь сургууль хөгжүүлэх сантай байж болох бөгөөд сангийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

39.12.Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, түүнийг зарцуулах, тайлгахаа журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

[/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

39.13.Боловсролын үнэлгээний байгууллага нь улсын төсөв, судалгааны ажлын орлого их, дээд сургуулийн элсэлтийн ерөнхий шалгалтын хураамжийн орлогоос санхүүжнэ.

[/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

39.14.Боловсролын магадлан итгэмклэх үндэсний зөвлөлийг үр дүн, гүйцэтгэлд суурilan гэрээний дагуу улсын төсвөөс зардлын тодорхой хувийг санхүүжүүлэх бөгөөд үйлчилгээний төлбөрийн хэмжээг Боловсролын магадлан итгэмклэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөл тогтооно.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дугээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

#### **40 дүгээр зүйл.Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт**

40.1.Төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг суурь зардал болон дундаж нормативт үндэслэсэн хувьсах зардал, сургалтын байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үнэлгээний үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлаар санхүүжүүлж болно.

[/Энэ хэсгийг 2021 оны 11 дугээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

40.2.Төрийн өмчтөрийн өмчийн боловсролын сургууль, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын тогтолцоог орон нутгийн төсвөөс, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрын нийт зардал, тусгай сургуулийн суралцагчийн үйлийн хоолны зардал, цэцэрлэгийн байршилыг харгалзан хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ашгийн болон ашгийн төлөө бус цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.

[/Энэ хэсэгт 2003 оны 1 дугээр сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2006 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2009 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсгийг 2016 оны 04 дугээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ хэсгийг 2018 оны 11 дугээр сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

40.3.Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тостон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинчлэн тогтооно.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2016 оны 4 дугээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

40.4. Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

40.4.1. цэцэрлэгт улсын төсөв, орон нутгийн төсөв, эцэг, эх, асран хамгаалагчаас өгөх төлбөр, өөрийн үйл ажиллагааны орлого;

[Энэ заалтад 2003 оны 1 дугээр сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[Энэ заалтад 2018 оны 11 дугээр сарын 02-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

40.4.2. ерөнхий боловсролын сургуульд улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн үйл ажиллагааны орлого;

[Энэ заалтад 2003 оны 1 дугээр сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[Энэ заалтад 2018 оны 11 дугээр сарын 02-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

40.4.3. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад улсын төсөв, өөрийн үйл ажиллагааны орлого;

[Энэ заалтад 2003 оны 1 дугээр сарын 03-ны өдрийн хууль, 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

40.4.4.их сургууль, дээд сургууль, коллеж, политехник коллежид улсын төсөв, сургалтын төлбөр, эрдэм шинжилгээний төсөлт ажлын болон өөрийн үйл ажиллагааны орлого;

[Энэ заалтад 2003 оны 1 дугээр сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[Энэ заалтад 2018 оны 11 дугээр сарын 02-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

40.4.5. Цэрэг, цагдаагийн дээд боловсрол эзэмшүүлэхтэй холбоотой зардлыг төр хариуцна.

40.5-[Энэ хэсгийг 2003 оны 1 дугээр сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон/](#)

40.5.Нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг сургуулийн байршил, хэв шинж, мэргэжлийн чиглэл, олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн сургалтын онцлог болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээтэй уялдуулан энэ хуулийн 40.3-т заасан сургалтын байгууллага тус бүрээ ялгавартай тогтоох бөгөөд аргачлалыг нь боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн, энэ хэсэгт 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

40.6.Дээд боловсролын сургалтын байгууллага болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчдад төрөөс үзүүлэх буцалтгүй тусламж, зээл, тэтгэлгийн хэмжээг Засгийн газар жил бүр тогтооно.

[Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн, энэ хэсэгт 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

40.7.Суралцагчаас хуульд заагаагүй төлбөр, хураамж авахыг хориглоно.

[Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

40.8.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн мэргэжлийг өмчийн хэлбэр үл харгалзан улсын төсвийн хөрөнгөөр 5 жил тутам дээшлүүлнэ.

[Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн, энэ хэсэгт 2016 оны 4 дугээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

#### **41 дугээр зүйл.Төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт**

41.1.Төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилтийн эх үүсгэн байгуулагчийн хөрөнгө, нэг сурагчид ногдох нормативт зардлын төсвөөс санхүүжүүлэх хэсэг, сургалтын төлбөр, хандив, хөнгөлөлттэй зээл, өөрийн үйл ажиллагааны орлогоос бүрдэнэ.

[Энэ хэсэгт 2014 оны оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

41.2.Төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчинг сайжруулах, тэдгээрийг багшлах боловсон хүчинээр хангахад Засгийн газар тогтоосон журмын дагуу дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

41.3.Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид төрөөс ногдох сургалтын нормативт зардлын хэмжээг тухайн боловсролын сургалтын байгууллагын сургалтын төлбөртэй нь уялдуулан Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно.

[Энэ хэсгийг 2014 оны оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

41.4.Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьят хүүхдэд монгол хэл, түүх, ёс заншил, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлж болох бөгөөд дэмжлэг үзүүлэх нөхцөл,

шаардлага, хэмжээг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

#### **42 дугаар зүйл.Боловсролын байгууллагын сургалтын орчин**

42.1.Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

[/Энэ хэсэгт 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

42.2.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага өөрийн харьяа хэвлэл, мэдээлэл, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнийг засварлах, үйлдвэрлэх, хангах зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах нэгжтэй байж болно.

[/Энэ хэсэгт 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

42.3.Цэцэрлэг, сургуулийн барилга байгууламж, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хоол хүнсний зүйл болон суралцагчийн эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлын норм, нормативыг холбогдо хууль тогтоомж, боловсролын стандартыг үндэслэн боловсрол, эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж мөрдүүлнэ.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

42.4.Ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллагыг хэвийн үйл ажиллагаа явуулахад хүрэлцэхүйц зориулалтын барилга байгууламж, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сурах бичиг, дотуур байраар хангах ажлыг үүсгэн байгуулагч хариуцна.

[/Энэ хэсэгт 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

42.5.Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, эдэлбэр газрыг зориулалтын дагуу ашиглана.

[/Энэ хэсэгт 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

42.6.Боловсролын сургалтын байгууллага нь барилга, хот төлөвлөлтийн норм, нормативыг баримтлан тогтоосон, сургалтад зориулсан эзэмшил газартай байна.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

42.7.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь шинээр барих сургууль, цэцэрлэгийн урт хугацааны төлөвлөлтийг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж, сургууль, цэцэрлэгийн эзэмшил, ашиглалтын эдэлбэр газрыг сургалтын орчинд тавигдах шаардлагад нийцсэн талбайн хэмжээний дагуу нөөцөд авах шийдвэр гаргана.

[/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

42.8.Энэ хуулийн 42.7-д заасны дагуу шинээр барих сургууль, цэцэрлэгийн нөөцийн газрыг өөр зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулах, худалдахыг хориглоно.

[/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

42.9.Дээд боловсролын сургалтын байгууллагын хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зориулалтын барилга байгууламж, сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн орчин, лаборатори, сургалтын хэрэглэгдэхүүн, дотуур байраар хангах ажлыг Удирдах зөвлөл хариуцна.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

#### **43 дугаар зүйл.Боловсролын харилцаанд оролцогчдын нийгмийн баталгаа**

43.1.Багш нийгмийн дараахь баталгаагаар хангагдана:

43.1.1.хөдөлмөрийн шинж чанар, мэргэжлийн онцлогт тохирсон цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, нехөх олговор, шагнал урамшуулал авах, хуульд заасан бусад хөнгөлөлт эдлэх;

43.1.2.багш, ажиллагчдын ээлжийн үндсэн амралтын хугацааг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна. Хөдөлмөрийн онцлогийг харгалзан багшид ажлын 33, захирал, эрхлэгч, орлогч захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, хичээлийн зохицуулагч, нийгмийн ажилтан, арга зүйч, дадлагын болон байрны багш, цэцэрлэгийн туслах багшид ажлын 15 өдрийн нэмэгдэл амралт тус тус олгоно.Хөдөлмөрийн тухай хуулийн 99.5, 99.6-д заасан ажилласан хугацаа, хөдөлмөрийн нөхцөлийг харгалзсан бусад нэмэгдэл амралт дээрх албан тушаалтанд хамаарахгүй;

[/Энэ заалтад 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

43.1.3.орон сууц барих буюу худалдан авахад зориулж хөнгөлөлттэй зээл, тусламж авах;

43.1.4.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт энэ хуулийн 43.1.2-т заасан албан тушаалд 25 ба түүнээс дээш жил ажилласан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход түүний үндсэн цалингаар тооцож нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас нь олгох бөгөөд шаардагдах зардлыг нь тухайн жилийн төсөвт тусгах;

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хууль, 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хууль, 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөн найруулсан/](#)

43.1.5.тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан багшид нэмэгдэл цалин, урамшил, бусад дэмжлэг үзүүлэх;

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

43.1.6./Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

43.1.7.Дараах этгээдэд 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох:

43.1.7.а.сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, сургууль, цэцэрлэгийн эмч;

43.1.7.б.сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгийн энэ хуулийн 43.1.7.а-д зааснаас бусад багш, туслах багш.

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн, 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

43.1.8.ерөнхий боловсролын сургуулийн эмч, бага ангийн багшид Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 7.8-д заасан нэмэгдлийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч сар бүр олгох;

[/Энэ заалтыг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн, Энэ заалтад 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

43.1.9.хуульд заасан бусад баталгаа.

[/Энэ заалтын дугаарт 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хууль, 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

43.2.Суралцагч нийгмийн дараах баталгаагаар хангагдана:

43.2.1.оршин суудаг газраасаа сургуульд тогтмол явах боломжгүй, өнчин буюу амьжиргааны түвшин доогуур суралцагчийг дотуур байраар хангах;

43.2.2.ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байранд төлбөргүй суух;

[/Энэ заалтад 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

43.2.3.сурагчийг хичээлийн жил эхлэх, дуусах болон улирлын амралтаар сургуульдаа ирэх, гэртээ буцахад эцэг, эх, асран хамгаалагчийн зардал, хүсэлтээр унаагаар үйлчлэх арга хэмжээг сургуулийн захиргаа, нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах;

43.2.4.оршин суудаг газраасаа өөр аймаг, хотод суралцаж байгаа оюутны жилд 2 удаа орон нутагтаа ирж, очих зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу хөнгөлөх;

43.2.5.нийтийн тээврийн хэрэгслээр хичээлдээ явах зайлшгүй шаардлагатай сурагч, оюутны нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зардлын 50 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний нөхөн олговрыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон журмын дагуу олгох;

[/Энэ заалтад 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт, 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар нэмэлт т оруулсан/](#)

43.2.6.Засгийн газраас тогтоосон журмын дагуу эмнэлэг, нийтийн хоол, соёл, урлагийн болон ахуйн үйлчилгээгээр үйлчлэх зардлыг хөнгөлөх;

43.2.7.суралцагчийн онцгой авьяас, чадварыг нээн илрүүлж хөгжүүлэх, урамшуулан дэмжих, өнчин, амьжиргааны түвшин доогуур, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг суралцаж байгаа оюутан, магистрантад Боловсролын зээлийн сангаас хөнгөлттэй нөхцөлөөр зээл, тэтгэлэг олгох;

[/Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

43.2.8.хөдөөгийн сумдын захиалга-гэрээний дагуу багш мэргэжлээр суралцаж байгаа оюутан, магистрантад Боловсролын зээлийн сангаас хөнгөлттэй нөхцөлөөр зээл, тэтгэлэг олгох;

[/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

43.2.9.сурлагагаар спортуудын онцгой амжилт гаргасан суралцагч-дад Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох;

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

43.2.10.мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид Засгийн газраас тогтоосон хэмжээ, нөхцөлийн дагуу тэтгэлгэг олгоно.

[/Энэ заалтыг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн, энэ заалтад 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

43.2.11.хуульд заасан бусад баталгаа.

[/Энэ заалтын дугаарт 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

43.3.Багш, суралцагчид үзүүлэх хөнгөлөлт, нөхөх олговор, тэтгэлэг, тэтгэмж, шагнал урамшил нь өмчийн хэлбэр харгалзахгүй адил тэгш байна.

43.4.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, бусад албан хаагчид үр дүнгийн урамшуулалт олгох бөгөөд уг урамшууллын хэмжээ, түүнийг олгох журмыг Төрийн албаны тухай хуулийн 31.3-т заасны дагуу Засгийн газар батална.

[/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

43.5.Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт энэ хуулийн 3.1.15-д заасан албан тушаалд 25 ба түүнээс дээш жил ажилласан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход түүний үндсэн цалингаас нь тооцож нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас нь олгох бөгөөд шаардагдах зардлыг нь тухайн жилийн төсөвт тусгана.

[/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн, 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

43.6.Энэ хуулийн 43.1.8-д заасан нэмэгдлийг Төрийн албаны тухай хуулийн 28.9-д заасны дагуу тогтооно.

[/Энэ хэсгийг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

43.7.Энэ хуулийн 43.1.4, 43.5-д заасан нэг удаагийн тэтгэмж тооцох цалингийн дундаж хэмжээ, тэтгэмж олгох шалгуур нөхцөлийг Төрийн албаны тухай хуулийн 30.2-т заасан журмыг баримтлан тогтооно.

[/Энэ хэсгийг 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ** **Боловсролын харилцаанд оролцогчдын нийтлэг эрх, үүрэг**

### **44 дүгээр зүйл.Багшийн эрх, үүрэг**

44.1.Багш дараах эрхтэй:

44.1.1.сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангуулах;

44.1.2.сургалтад шинжлэх ухааны дэвшилт арга барил, боловсролын стандартад нийцсэн сурх бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгон хэрэглэх;

44.1.3.суралцагч болон түүний эцэг, эх, асран хамгаалагчид шаардлага тавих, зөвлөгөө өгөх;

44.1.4.суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, тэдний авьяас, бие сэтгэцийн хөгжилтөд тодорхойлолт өгөх;

44.1.5.суралцагчийг сонгон суралцуулах, мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулах;

44.1.6.судалгаа шинжилгээний ажил хийх, багшийн мэргэжлийн болон боловсролын зэрэг хамгаалах, мэргэжлийн цол хүртэх;

44.1.7.хүүхдийн эрүүл мэнд, эрх ашгийг хохироосон эцэг, эх, асран хамгаалагчийн талаар насанд хүрээгүй суралцагчаа төлөөлөн зохих байгууллагад гомдол гаргаж шийдвэрлүүлэх.

**44.1.8./Энэ залтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/**

44.2.Багш дараах үүрэгтэй:

44.2.1.багшийн ёс зүй, нэр төрийг эрхэмлэн сахих;

44.2.2.боловсролын стандартыг хэрэгжүүлэх;

44.2.3.онолын мэдлэг, заах арга, ур чадвараа дээшлүүлэх;

44.2.4.суралцагчдыг ялгаварлан гадуурхахгүй байх, нэр төрийг нь хүндэтгэн хамгаалах;

44.2.5.суралцагч бүрийн онцлог байдлыг хүлээн зөвшөөрч хүнлэг харьцах, өөрөө өөрийгөө хөгжүүлэх, бие хүн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлэх;

44.2.6.суралцагчийн бие даасан байр суурь, үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;

44.2.7.суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдалд анхаарал тавих.

44.2.8.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн бие эрхтэн, хөгжлийн онцлогийг хүндэтгэн үзэж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч бусдын адил тэгш байх нөхцлийг бүрдүүлэх.

[/Энэ заалтыг 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

44.3.Багш нь суралцагчийн бие маходид халдах, тэдэнд сэтгэл санааны дарамт үзүүлэх, хувийн нууцыг нь задруулахыг хориглоно.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

44.4.Багш нь хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхдээ багшийн ёс зүйн дүрмийг баримталж ажиллана.

[/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

#### **45 дугаар зүйл.Суралцагчийн эрх, үүрэг**

45.1.Суралцагч дараах эрхтэй:

45.1.1.суралцах нөхцөл бололцоогоор хангуулах;

45.1.2.сургалтын төлөвлөгөөнд заавал судлахаар тусгаагүй хичээлээс сонгон судлах;

45.1.3.сургууль, багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар санал гаргах, шүүмжлэх, шаардлага тавих;

45.1.4.суралцах хугацаа, хэлбэрийн талаар санал тавьж шийдвэрлүүлэх;

45.1.5.хууль тогтоомжид заасны дагуу тусламж авах, хөнгөлөлт эдлэх;

45.1.6.гэрээнд өөрөөр заагаагүй бол сургууль төгсөгч эзэмшсэн буюу сонирхсон мэргэжлийн дагуу эрхлэх ажлаа хөдөлмөрийн зах зээл дээр чөлөөтэй сонгох;

45.1.7.сургалтын төлбөр, хандивын зарцуулалт, ашиглалтын талаар мэдээлэл авах, хяналт тавих;

45.1.8.уламжлалт соёл, зан заншлыг өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах.

[/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

45.2.Суралцагч дараах үүрэгтэй:

45.2.1.сургалтын хөтөлбөрийн агуулгыг хугацаанд нь бүрэн эзэмших;

45.2.2.багшаас тавьсан шаардлага, өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;

45.2.3.бие дааж суралцах арга барилыг эзэмших;

45.2.4.багш, шавийн харилцааг хүндэтгэн дээдлэх;

45.2.5.сургуулийн дотоод журмыг хүндэтгэн сахих;

45.2.6.сургалтын төлбөрийг гэрээний дагуу хугацаанд нь төлөх.

#### **46 дугаар зүйл.Эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг**

46.1.Эцэг, эх, асран хамгаалагч дараах эрхтэй:

46.1.1.хүүхдээ аль сургуульд, ямар хэлбэрээр суралцуулахыг зохих журмын дагуу сонгох;

46.1.2.боловсролын сургалтын байгууллага, багшийн үйл ажиллагаатай холбогдсон санал, хүсэлт гаргах;

46.1.3.хүүхдийнхээ мэдлэг, чадвар, авьяас, бие, сэтгэцийн талаар сургууль, багшаас гаргасан тодорхойлолттой танилцах.

46.2.Эцэг, эх, асран хамгаалагч дараах үүрэгтэй:

46.2.1.хүүхдийн авьяас, чадварыг бага наснаас нь дэмжин хөгжүүлэх, боловсрол эзэмшихэд нь шаардагдах нөхцөлийг бүрдүүлэх, багштай хамтран ажиллах, мэргэжлээ сонгоход нь хүүхэддээ туслах;

46.2.2.сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдуулан сургууль, багшаас тавьсан шаардлагыг биелүүлэх;

46.2.3.хүүхэддээ 16 хүртэл насанд нь суурь боловсрол заавал эзэмшиүүлэх, суралцах хүсэл, сонирхлыг нь хааж боогдуулахгүй байх;

46.2.4.хүүхдийг гэр бүлийн орчинд сургах арга барил эзэмших;

46.2.5.боловсрол эзэмшихэд нь хүүхэддээ байнгын дэмжлэг, туслалцаа үзүүлэх, урамшуулан дэмжих;

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

46.2.6.хүүхдийнхээ суралцах, төлөвших, авьяасыг хөгжүүлэх сургалт, үйл ажиллагааны үйл явц, үр дүнтэй танилцах.

[/Энэ заалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

46.3.Хүүхдийнхээ суралцах, төлөвших, авьяас, чадварыг хөгжүүлэх асуудлаар боловсролын сургалтын байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж болно.

[/Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

#### **47 дугаар зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг**

47.1.Аж ахуйн нэгж, байгууллага дараахь эрхтэй:

47.1.1.мэргэжилтэн бэлтгүүлэх, ажиллагчдын мэргэшлийг дээшлүүлэх захиалгыг холбогдох боловсролын сургалтын байгууллагад өгөх, гэрээ байгуулах;

47.1.2.гэрээ, захиалгаар суралцагчийн талаар санал гаргах, шаардлага тавих;

47.1.3.ажилтандaa боловсрол олгох, түүний мэргэшил дээшлүүлэх сургалт зохион байгуулах;

47.1.4.боловсролын байгууллагыг бэхжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, ивээн тэтгэсний төлөө хууль тогтоомжид заасан зохих хөнгөлөлт өдлэх.

47.2.Аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэгтэй:

47.2.1.гэрээний дагуу суралцагчийг хүлээн авч үйлдвэрлэлийн дадлага хийлгэх нөхцөл, бололцоогоор хангах;

47.2.2.гэрээ, захиалгаар суралцагчийн сургалтын зардлыг төлөх;

47.2.3.ажилтан бие дааж сурч боловсрох, хүүхдээ сургахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

#### **ДОЛДУГААР БҮЛЭГ**

##### **Бусад зүйл**

#### **48 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

48.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

48.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

48.3.Удирдах ажилтны болон багшийн ёс зүйг ноцтой зөрчсөн бол багшлах эрхийг хасах арга хэмжээ авна.

[/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн нийтуулсан/](#)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР